

## МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

Огноо: 2014/09/08/ Дугаар: 298 Улаанбаатар хот

### “Чиглэл батлах тухай”

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Өрсөлдөөний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг тус тус үндэслэн хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зохистой бүрдлийг бий болгох зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2014-2016 онд баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2014-2016 онд баримтлах чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2012-2013 онд баримтлах чиглэл батлах тухай” 2012 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 39 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.УДВАЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХОД 2014-2016 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

**Нэг. Нийтлэг зүйл**

- 1.1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “Тусгай зөвшөөрөл” гэх) хүсэгчийн хүсэлтийг хэлэлцэж, шийдвэр гаргахад энэхүү баримтлах чиглэлийг удирдамж болгоно.
- 1.2. Тусгай зөвшөөрөл олгох үйл явц нь “Эрүүл мэндийн байгууллага байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох” ба “Тусгай зөвшөөрөл олгох” гэсэн үе шаттай хэрэгжих бөгөөд энэхүү баримт бичигт заасан тусгай зөвшөөрөл олгох *тэргүүлэх чиглэл болон хязгаарлалт хийх* чиглэлийг үндэслэнэ.
- 1.3. Тусгай зөвшөөрөл олгох *тэргүүлэх чиглэлд* эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон салбарын хүний нөөцийн хөгжлийн тогтолцоонд олон улсын стандарт, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхэд тэргүүн ээлжинд үндэсний хөрөнгө оруулалт, улмаар манай оронд эмчлэх боломжгүй тусламж, үйлчилгээнд гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зарчим баримтална.
- 1.4. Тусгай зөвшөөрөл олгоход баримтлах энэхүү чиглэл нь тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас томилогдсон ажлын комисс болон эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж байгууллагад хамаарна.
- 1.5. Эрүүл мэндийн газрын дэргэдэх тусгай зөвшөөрлийн ажлын алба хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг хоёр жил тутамд үнэлэн, үнэлгээний дүнг, дараагийн хоёр жилд баримтлах чиглэлийн саналын хамт 12 дугаар сарын 01-ний дотор ЭМЯ-ны

дэргэдэх Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисст ирүүлнэ.

### **Хоёр. Тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл**

2.1 Улсын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагад дараах чиглэлээр тусгай зөвшөөрөл олгоно. Үүнд:

2.1.1 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Монгол улсад оношлох, эмчлэх боломжгүй төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ

2.1.2 Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ

2.1.3 Импорт орлох эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, түүний

дагалдах хэрэгсэл, протез болон ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах,

халдваргүйжүүлэх бодисын үйлдвэрлэл эрхлэх

2.2 Тухайн орон нутгийн засаг захиргаанаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх асуудлыг шийдэж чадаагүй алслагдсан байршилд байрлан, хүн амд тусламж, үйлчилгээг ойртуулж, хүртээмжийг нэмэгдүүлсэн тусламж үйлчилгээг дэмжинэ.

### **Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход хязгаарлалт хийх чиглэл**

3.1. Үйл ажиллагааны болон байршлын давхардал бүхий дараах эрүүл мэндийн байгууллагын төрөл, үйлчилгээ:

- Бүх төрлийн клиник, эмнэлэг, сувиллын тусламж, үйлчилгээ;
- Эмийн сангийн үйлчилгээ;
- Хараа зүйн тусламж, үйлчилгээ;
- Эмчилгээний гоо заслын үйлчилгээ

3.2 Үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалт бүхий дараах эрүүл мэндийн байгууллагын төрөл, үйлчилгээ:

- Биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх, худалдах;
- Зах зээлийн тандалт судалгаагаар эмийн нэр төрөл, тоо хэмжээ нь хангалттай нь тогтоогдсон эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх
- Хэрэгцээг судалж тогтоогоогүй, ижил төстэй технологиор үйлдвэрлэсэн, зах зээлд нэвтэрсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур